



## ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

Сэнтрал Тауэр 16 давхар, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот 14200, УБД: 9011007001  
Утас: (976) 70122279, 70132279, Факс: (976) 11-322279  
contact@mmc.mn, www.energyresources.mn

2024.06.17 № 483

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хяналтын журмаар гомдол гаргах тухай

“Энержи Ресурс” ХХК-ийн нэхэмжлэлтэй, хариуцагч “Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газар”-т холбогдох

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн илүү төлөлтийг баталгаажуулахаас татгалзсан Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын 2023.04.04-ний өдрийн 01//352 дугаар шийдвэр хууль бус болохыг тогтоолгож, үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн 208,688,214,552 төгрөгийг буцаан олгохыг Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт даалгах;
2. Монгол Улсын Засгийн газрын 2019.12.25-ны өдрийн 465 дугаартай тогтоолын хавсралт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.1.2 дахь хэсэг, 2021.06.23-ны өдрийн 174 дүгээр тогтоол “Энержи Ресурс” ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцаанд үйлчлэхгүй болохыг тогтоолгож, хүлээн зөвшөөрүүлэх

шаардлага бүхий захиргааны хэргийг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2024 оны 3 дугаар 18-ны өдрийн 243 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

Анхан шатны шүүхийн шийдвэрт хариуцагчийн зүгээс давж заалдах журмаар гомдол гаргасныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 334 дугаартай магадлалаар гомдлын зарим хэсгийг хангаж, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчдийн зүгээс давж заалдах шатны шүүхийн 334 дугаартай магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5, 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэгт заасан журмын дагуу, мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.4-т заасныг тус тус үндэслэн дараах гомдлыг гаргаж байна.

*Нэг. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн илүү төлөлтийг баталгаажуулахаас татгалзсан Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01//352 дугаар шийдвэр хууль бус болохыг тогтоолгож, үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн 208,688,214,552 төгрөгийг буцаан олгохыг Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт даалгах” шаардлагын тухайд:*

1. Давж заалдах шатны шүүхийн магадлалын ХЯНАВАЛ хэсгийн 2.1.7-д “Нэхэмжлэгчийн тус шаардлагын талаар анхан шатны шүүхээс “...Засгийн газрын тогтоолууд нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт төдийгүй, Ашигт малтмалын тухай хууль болон Хөрөнгө

оруулалтын тухай хуулийн бүрдэл хэсэг болохын хувьд тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн ашиг сонирхлыг хөндөхөөргүй байх ёстой” гэж зөв дүгнэсэн боловч хариуцагч захиргааны байгууллагаас Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.1-д зааснаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг илүү төлсөн татварыг буцаан олгох эсэх асуудлыг хяналт, шалгалт явуулах замаар тогтоосны үндсэн дээр шийдвэрлэхээр байхад анхан шатны шүүх нэхэмжлэгчээс тодорхойлсон 208,688,214,552 төгрөгийн дүнгээр тооцон буцаан олгохоор шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна. Энэ талаарх хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “...Шүүхийн шийдвэрийг сонсгохдоо татвар төлөгчид буцаан олгох татварын хэмжээг тодорхойлон олгох асуудал нь татварын албаны эрхийн асуудал байна гэж танилцуулсан атлаа бичгийн хэлбэрт шийдвэрээ баталгаажуулахдаа шууд 208 тэрбум төгрөгийг хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтээр олгохыг татварын албанд даалган шийдвэрлэсэн нь ойлгомжгүй байна...” гэх гомдол үндэслэлтэй.” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

2. Нэхэмжлэгч “Энержи Ресурс” ХХК нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар Татварын ерөнхий газрын том татвар төлөгчийн газарт 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр 216 дугаартай албан бичгээр илүү төлсөн татварын баталгаажуулахаар хандсан. Гэвч хариуцагчаас нэхэмжлэгчийн хүсэлтийг хангахаас татгалзаж, маргаан бүхий захиргааны акт болох 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр 01/352 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр “...Иймд танай компанийн 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд заасан хувь хэмжээг 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 001 дугаартай гэрчилгээ (хавсралт)-ээр тогтворжуулсан хувь хэмжээнд хуулиар өөрчлөлт ороогүй байх тул илүү төлөгдсөн гэх 221.4 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг баталгаажуулах боломжгүй болохыг үүгээр мэдэгдье.” гэж шийдвэрлэсэн.
3. Өөрөөр хэлбэл хариуцагчийн зүгээс “Энержи Ресурс” ХХК-ийн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн илүү төлөлтийг баталгаажуулах боломжтой байсан ч хүсэлтийг хангахаас үндэслэлгүйгээр татгалзсан.
4. Улмаар нэхэмжлэгчээс хариуцагчийн дээрх шийдвэрийг эс зөвшөөрч 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 329 дугаартай албан бичгээр Татварын ерөнхий газарт холбогдуулан гомдол гаргасан бөгөөд тус газраас 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 04/1245 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” гомдлыг хангахаас татгалзсан боловч албан бичигтээ “...Том татвар төлөгчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр 01/352 дугаартай албан бичиг хууль зүйн үндэслэлтэй байна. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220, 2019 оны 342 дугаар тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана уу.” гэсэн.
5. Хариуцагч Том татвар төлөгчийн газраас “Энержи Ресурс” ХХК-ийн АМНАТ төлөх харилцаанд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар зүйлийн 23-ны өдрийн 174 дүгээр тогтоолын үйлчлэлд үндэслэлгүйгээр хамруулж, 208,688,214,552 төгрөгийн АМНАТ-ийг илүү төлүүлсэн атал, дээд шатны захиргааны байгууллага болох Татварын ерөнхий газраас тус компанийг үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг даалгасан нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэсэн.
6. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дэлхийн тэргүүлэх аудитын компани болох “ПрайсвотерхаусКүүперс” ТМЗ ХХК-аар АМНАТ-ийн төлсөн төлбөрийн дүнг хянан баталгаажуулж, шүүхэд нотлох баримтаар гаргаж өгсөн бөгөөд тус байгууллагаас 2021.05-2023.09 сарыг дуусах хүртэлх хугацаанд нэхэмжлэгчийн экспортод гаргасан нүүрсний хэлцлийн үнээс 65.4 хувиар өндөр дүнгээс АМНАТ тооцож нийт 498,747,536,406 төгрөгийн АМНАТ төлүүлсний 208,688,214,552 төгрөг нь илүү төлсөн болохыг хянан баталгаажуулсан. Хариуцагчийн зүгээс тус дүгнэлтэд дурдагдсан Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220, 2021 оны 174 дүгээр тогтоолуудын зөрүү АМНАТ-ийн 208,688,214,552 төгрөгийн дүнтэй маргаж байгаагүй болно.

7. Тогтворжуулах гэрчилгээ олгох үеийн байдлаар мөрдөгдөж байсан Ашигт малтмалын хууль тогтоомж болох Ашигт малтмалын тухай хуулийн 47.6 дах заалтаар АМНАТ-ийн хувийг гооцох, төлбөр ногдуулах аргачлалыг батлах эрхийг Засгийн газарт олгосон байсны дагуу 2014 оны 220 дугаар тогтоолыг нийтээр дагаж мөрдүүлж байсныг 2019 оны 3-р сарын 26-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр журам болгосноор Засгийн газраас 2019 оны 342, 2019 оны 465 болон 2021 оны 174 дүгээр тогтоолуудаар өмнө мөрдөж байсан аргачлалыг өөрчилснөөр тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нэхэмжлэгчийн төлөх АМНАТ-ийн хувь болон хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлсэн. Үүнд:

	220 дүгээр тогтоолын дагуу төлөх АМНАТ-ийн хэмжээ /төг/	342 дүгээр тогтоолын дагуу төлөх АМНАТ-ийн хэмжээ /төг/	465 ба 174 дүгээр тогтоолын дагуу төлүүлсэн АМНАТ-ийн хэмжээ /төг/	342-р тогтоолоор нэмэгдүүлэх дүн /төг/	465 ба 174-р тогтоолоор нэмэгдүүлсэн дүн /төг/
2021 он	15,419,791,013.63	46,177,274,271.39	46,177,274,271.39	30,757,483,257.76	30,757,483,257.76
2022 он	127,958,572,772.54	233,345,982,618.88	238,104,184,369.81	105,387,409,846.34	110,145,611,597.27
2023.09	146,680,958,066.87	194,983,096,588.59	214,466,077,764.30	48,302,138,521.72	67,785,119,697.43
<b>Нийт</b>	<b>290,059,321,853</b>	<b>474,506,353,479</b>	<b>498,747,536,406</b>	<b>184,447,031,626</b>	<b>208,688,214,552</b>

8. Дээрх үйл баримтад анхан шатны шүүхийн шийдвэрийн ҮНДЭСЛЭХ хэсгийн 38 болон 40-д дараах байдлаар үндэслэл бүхий дүгнэлт хийсэн.

38. Нэхэмжлэгч “Энержи Ресурс” ХХК нь ашигт малтмал ашигласны төлбөрийг хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас илүү төлсөн гэж үзэж, илүү төлүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг олон улсын хөндлөнгийн аудитын “ПрайсвотерхаусКүүперс” ТМЗ ХХК-аар шалгуулан, уг байгууллагаас гаалийн бүрдүүлэлтийн албан ёсны бүртгэл мэдээлэлд үндэслэн тайланг гаргасан байх бөгөөд уг хөндлөнгийн аудитын тайлангаар “Энержи Ресурс” ХХК-ийн экспортод гаргасан баяжуулсан коксжих нүүрсэнд төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2021 оны 5 дугаар сараас 2023 оны 10 дугаар сарын хооронд нийт 208,688,214,552 төгрөгөөр нэмэгдүүлсэн болохыг баталгаажуулсан байх бөгөөд шүүхээс үүнийг нотлох баримтаар хүлээн авах боломжтой гэж үзсэн болно.

...

40. Иймд хавтаст хэрэгт авагдсан баримтуудаар нэхэмжлэгч компани Засгийн газрын 2021 оны 174 дүгээр тогтоолоор төлөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 208,688,214,552 төгрөгөөр нэмэгдүүлэн төлсөн болох нь тогтоогдож байх тул Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг доор дурдсан дарааллын дагуу шийдвэрлэнэ, 49.1.1-т буцаан олгох гэж зааснаар Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01/352 дугаар шийдвэр хууль бус болохыг тогтоож, үндэслэлгүйгээр илүү төлүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 208,688,214,552 төгрөгийг буцаан олгохыг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт даалгах нь зүйтэй гэж шүүх үзлээ.

9. Хариуцагч Том татвар төлөгчийн газрын маргаан бүхий 01/352 дугаар шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг заасан захиргааны акт болохын хувьд шүүхийн хяналтын хүрээнд багтах буюу захиргааны актын хууль ёсны, үндэслэл бүхий байх, шийдвэр чиглэсэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын хөндсөн эсэхэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан дээрх зорилтын хүрээнд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар захиргааны хэргийн шүүх хянаж, шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.

10. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчээс илүү төлсөн 208,7 тэрбум төгрөгийн АМНАТ-ийг хариуцагчаас буцаан гаргуулах шаардлагатай холбоотойгоор буюу уг шаардлагын үндэслэлийг нотолж шүүхэд гаргасан /олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитын байгууллага болох “ПрайсвотерхаусКүүперс” ТМЗ ХХК (англиар “Pricewaterhouse Coopers” буюу товчилсноор “PWC”) -р баталгаажуулсан/баримтыг хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж цугларсан баримт гэж үзээгүй.

11. Хариуцагчийн зүгээс маргаан бүхий захиргааны актаар нэхэмжлэгч Энержи Ресурс ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагад хамаарах хугацаа болох 2021 оны 5 сарын 01-нээс 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд АМНАТ төлөх харилцаанд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаартай тогтоол үйлчлэхгүй, харин 2021 оны 174 тогтоолоор илүү төлөлтийг баталгаажуулахаар үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэрт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт буюу хуульд заасан шаардлага хангасан нотлох баримтаар тогтоогдсон дүн болох 208,688,214,552 төгрөгөөр илүү төлөлтийг баталгаажуулахыг даалгаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй.
12. Учир нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус, хөндлөнгийн аудитын байгууллага болох “ПрайсвотерхаусКүүперс” ТМЗ ХХК нь гаалийн бүрдүүлэлтийн тоон мэдээлэл, гаалийн мэдүүлэгийн тооцоо нийлсэн акт, гаалийн мэдүүлэг, үнэ нийтлэх эрх бүхий ажлын хэсгийн “Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний зарлагдаж буй олон улсын зах зээлийн үнэ”-ийн сар бүрийн мэдээлэл, татварын тайлан зэрэг нэхэмжлэгчээс гарах боломжгүй төрийн эрх бүхий байгууллагад хадгалагдаж буй дата мэдээлэлд үндэслэж, татварын тайлангийн хянан, баталгаажуулалтыг хийсэн учраас илүү төлсөн 208,7 тэрбум төгрөгөөс өөр дүн тооцоологдох боломжгүй юм.
13. Гэтэл давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн хариу тайлбар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цугларсан баримтуудад буруу дүгнэлт хийж, анхан шатны шүүхийг нэхэмжлэгчийн өөрөө тодорхойлсон үнийн дүнгээр шууд олгохоор шийдвэрлэсэн мэтээр дүгнэн, шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна.
14. Мөн давж заалдах шатны шүүхийн магадлалын ТОГТООХ хэсгийн 1-т “... “Энержи Ресурс” ХХК-с гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн илүү төлөлтийг баталгаажуулахаас татгалзсан Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01/352 дугаар шийдвэр хууль бус болохыг тогтоож, илүү төлөлт байгаа эсэхийг зохих журмын дагуу хянаж, шалгахыг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт даалгасугай” гэж анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.
15. Ингэхдээ маргаан бүхий захиргааны акт болох Том татвар төлөгчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 01/352 дугаар шийдвэрийг хууль бус болохыг тогтоосон боловч, “Энержи Ресурс” ХХК-ийн АМНАТ төлөх харилцаанд илүү төлөлт байгаа эсэхийг зохих журмын дагуу хянаж, шалгахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй бөгөөд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг өнөөдрийг хүртэл зөрчигдсэн хэвээр байгаагийн улмаас үндэслэлгүй төлүүлсэн татварын дүн 2024 оны 4-р сарын байдлаар 28.2 тэрбум төгрөгөөр нэмэгдээд байна.
16. Дээр дурдсанчлан хариуцагчийн зүгээс хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан 208,688,214,552 төгрөгийн АМНАТ-ийн илүү төлөлтийн дүнтэй хариуцагч маргаагүй бөгөөд дээд шатны захиргааны байгууллагаас нэхэмжлэгч компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг даалгасан болно.
17. Анхан шатны шүүхээс Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 174 дүгээр тогтоолыг баталсан 2021.06.23-ны өдрийн Засгийн газрын хуралдааны 36 дугаар дэлгэрэнгүй тэмдэглэлд хийсэн үзлэгээр тогтоолын төслийг боловсруулсан Монгол Улсын Сангийн сайд

Б.Жавхлан төлөх АМНАТ-ын хувь болон хэмжээг 22 хувиар нэмэгдүүлнэ хэмээн танилцуулсан нь хэрэгт нотлох баримтаар авагдсан байгаа. Энэ нь тус тогтоол нь төлөх АМНАТ-ийн хувь, хэмжээг нэмэгдүүлсэн үйл баримтыг нотлох тул уг тогтоол нэхэмжлэгчийн АМНАТ төлөх харилцаанд хамаарахгүй болохыг тогтоосон анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй.

18. Өөрөөр хэлбэл Ашигт малтмалын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 174 дүгээр тогтоолыг батлахдаа АМНАТ-ийн хувь, хэмжээг нэмэгдүүлж байгаа талаар тодорхой дурдсан атал шүүхээс нэхэмжлэгч “Энержи Ресурс” ХХК-д “илүү төлөлт байгаа эсэхийг зохих журмын дагуу хянаж, шалгахыг” гэж хариуцагчид даалгаж буй нь үндэслэлгүй байна.

*Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 465 дугаартай тогтоолын хавсралт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.1.2 дахь хэсэг, 2021.06.23-ны өдрийн 174 дүгээр тогтоол “Энержи Ресурс” ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцаанд үйлчлэхгүй болохыг тогтоолгож, хүлээн зөвшөөрүүлэх” шаардлагын тухайд:*

19. Дээр дурдсанчлан нэхэмжлэгчийн зүгээс нэхэмжлэлийн 2 дахь шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.3<sup>1</sup>, 106 дугаар зүйлийн 106.3.5<sup>2</sup>-д заасны дагуу “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлээн зөвшөөрөх” буюу “Монгол Улсын Засгийн газрын 2019.12.25-ны өдрийн 465 дугаартай тогтоолын хавсралт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.1.2 дахь хэсэг, 2021.06.23-ны өдрийн 174 дүгээр тогтоол “Энержи Ресурс” ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцаанд үйлчлэхгүй болохыг тогтоолгож, хүлээн зөвшөөрүүлэх” гэж тодорхойлж нэхэмжлэл гаргасныг анхан шатны шүүхээс Хөрөнгө оруулалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн хангаж шийдвэрлэсэн.

20. Гэтэл давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр өөрчлөлт оруулж, нэхэмжлэлийн 2 дахь шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1, 93 дугаар зүйлийн 93.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3-т заасныг үндэслэл иш татаж, хууль хэрэглээний илэрхий алдаа гаргаж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байх бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1-т заасан “шүүхийн хууль хэрэглээний зөрүү арилгах” болон 123.2.4-т заасан “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын нийтлэг ач холбогдолтой” гэх Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэлэлцэх үндэслэлд хамаарч байна.

21. Учир нь нэхэмжлэгчийн зүгээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.3-т заасан “нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгож, хүлээн зөвшөөрүүлэх” шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан. Энэ төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргахад i) нэхэмжлэлийн бусад төрлүүдийг гаргах боломжгүй, гаргасан ч ижил үр дүнд хүрэхээргүй байх”, ii) эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох талаарх нэхэмжлэгчийн онцгой ашиг сонирхолтой байх гэдэг үндсэн 2 урьдчилсан нөхцөл

<sup>1</sup> Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 52 дугаар зүйлийн 52.5 “Энэ хуулийн 52.2.4-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлд дараахь зүйл хамаарна.”, 52.5.3 “нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг”  
<sup>2</sup> Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 “Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана”, 106.3.5 “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрөх”

- хангагдсан байхыг шаардах бөгөөд харин давж заалдах шатны шүүхийн магадлалд дурдсанчлан Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1, 93 дугаар зүйлийн 93.1-т заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар Монгол Улсын Засгийн газар болон хариуцагч Татварын ерөнхий газарт хандаж гомдол гаргасан байхыг шаарддаггүй болно.
22. Энэ талаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт, байгуулсан гэрээ илт хууль бус болох, **эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох** болон захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлд энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа үл хамаарна.” гэж тодорхой заасан байна.
23. Өөрөөр хэлбэл “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох” шаардлагын хувьд нэхэмжлэл гаргах хугацааг хуулиар заагаагүй тул хэдийд ч шүүхэд гаргаж болох бөгөөд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагагүй болно.
24. Мөн Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 30 дугаартай тогтоолын ТАЙЛБАРЛАХ нь хэсгийн **3-т** “...Нийтийн эрх зүйн харилцааг тогтоолгох нэхэмжлэлийн нэгдүгээрт, хүн, хуулийн этгээдийн зүгээс нэхэмжлэлийн бусад үндсэн төрлүүдийг (хүчингүй болгох, даалгах) гаргах боломжгүй, гаргасан ч ижил үр дүнд хүрэхээргүй байх тохиолдолд, хоёрдугаарт, нэхэмжлэгчийн хувьд нэхэмжлэлээр шаардаж буй **нийтийн эрх зүйн харилцааг зайлшгүй шүүхээр тогтоолгох хамгаалагдахуйц ашиг сонирхол байгаа тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хүлээн авна.**” гэж, **7-д** “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.5-д заасан “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлээн зөвшөөрөх” гэдгийг нэхэмжлэгчийн тогтоолгохыг шаардаж буй нийтийн эрх зүйн харилцаа байгаа нь, эсхүл байхгүй нь тогтоогдсон бөгөөд **шүүхийн шийдвэр гарснаар** нэхэмжлэгчийн хувьд ямар нэгэн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, эсхүл дуусгавар болох зэргээр эрх зүйн тодорхой үр дагавар үүсэх буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хамгаалагдах боломжтой эсхүл боломжгүй бол **шүүхээс тухайн эрх зүйн харилцаа байгааг, эсхүл байхгүйг тогтоосон шийдвэр гаргах** бөгөөд уг заалтын “... тогтоож, хүлээн зөвшөөрөх” гэсэн нь эрх зүйн өөр өөр үр дагаврыг үүсгэхгүй, ижил агуулгатай гэж ойлгоно.” гэж тус тус тайлбарласан байна.
25. Монгол Улсын Дээд шүүхийн дээрх тайлбарт “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох” нэхэмжлэлийн шаардлага, түүний урьдчилсан нөхцөлийг тодорхой тайлбарласан байхаас гадна, уг нэхэмжлэлийн шаардлагын хувьд хувь хүн, хуулийн этгээдээс зөвхөн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой бөгөөд давж заалдах шатны шүүхийн магадлалд дурдсанчлан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар дээд шатны захиргааны байгууллага эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх боломжгүй юм.
26. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага өөрөө “нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох, хүлээн зөвшөөрөх” шийдвэр гаргах боломжгүй, эрхгүй болох нь тодорхой атал давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн 2 дахь шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3-т зааснаар урьдчилан шийдвэрлэх шаардлагыг биелүүлээгүй гэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хууль хэрэглээний илэрхий тодорхой, байж боломжгүй алдаа гаргасан гэж үзэж байна.
27. Түүнчлэн давж заалдах шатны шүүхийн магадлалын ХЯНАВАЛ хэсгийн 2.2.1-т “Энержи Ресурс” ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан 4 шаардлага бүхий захиргааны хэргийг иш татаж, 2.2.2-т “Хэдийгээр энэ талаар анхан шатны шүүх мэдэх боломжгүй боловч давж заалдах шатны шүүхийн тухайд энэ нь маргаан бүхий Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 174 дүгээр

тогтоолтой тус тус маргаж байгаа талаар мэдэх боломжтой буюу нэгэнт илэрхий үйл баримт юм.” гэсэн дүгнэлт хийсэн нь ойлгомжгүй бөгөөд тодорхойгүй байна.

28. “Энержи Ресурс” ХХК нь хариуцагч Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан:

- 1. Монгол Улсын Засгийн газрын 2021.06.23-ны өдрийн 174 дүгээр тогтоол;
- 2. Монгол Улсын Засгийн газрын 2016.02.01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр” гэх хүснэгтийн 7-д заасан “БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн үнэ (<http://en.sxcoal.com>)” гэх хэсэг;
- 3. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоолын 4 дэх заалт;
- 4. Монгол Улсын Засгийн газрын 2019.12.25-ны өдрийн 465 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.1.2, 2.2 дахь заалтуудыг тус тус хүчингүй болгуулах шаардлага бүхий нэхэмжлэл буюу

дээр дурдсан Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, тогтоолуудын зарим заалт нь Ашигт малтмалын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан “хэм хэмжээний актад тавигдах шаардлага”-г зөрчсөн гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргасныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс захиргааны хэрэг үүсгэн, анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа болно.

29. Харин тус компанийн зүгээс Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг “Монгол Улсын Засгийн газрын 2019.12.25-ны өдрийн 465 дугаартай тогтоолын хавсралт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.1.2 дахь хэсэг, 2021.06.23-ны өдрийн 174 дүгээр тогтоол “Энержи Ресурс” ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцаанд үйлчлэхгүй болохыг тогтоолгож, хүлээн зөвшөөрүүлэх” гэж тодорхойлсон бөгөөд нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, шүүхийн харъяалалын хувьд огт хамааралгүй, өөр өөр хариуцагчид холбогдох тусдаа захиргааны хэргүүд юм.

30. Түүнчлэн давж заалдах шатны шүүхээс магадлалын ХЯНАВАЛ хэсэгт тус компанийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны хэргийг иш татсан атлаа, ТОГТООХ хэсэгт огт дурдалгүй, зөвхөн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй гэх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3 дахь хэсэгт заасныг үндэслэсэн нь тодорхойгүй байна.

31. Магадлалын ХЯНАВАЛ хэсгийн 2.1.4-т “...Мөн Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д Хувь хүн, хуулийн этгээдийн Монгол улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулахад харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, баталгаажуулахаар албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. 15.8-д Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.2, 15.4, 15.7, 15.18-д зааснаар ирүүлсэн хүсэлт, саналыг хүлээн авснаас хойш ажлын долоон өдөрт багтаан хянаж буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж, энэ тухай албан татвар төлөгчид бичгээр буюу цахим хэлбэрээр мэдэгдэж, буцааж олгох албан татварын хэмжээ, өрийн дүн зэргийг хянан баталгаажуулж, албан татвар буцаан олгох саналыг ажлын хоёр өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэснийг тус тус зөрчжээ гэж маргаж буй үйл баримтанд хамааралгүй дүгнэлт өгсөн нь ойлгомжгүй бөгөөд магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангахгүй, Захиргааны хэрэг

хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1-т заасан “шүүхийн хууль хэрэглээний зорuu арилгах” гэх Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэлэлцэх үндэслэлд хамаарч байна.

- 32. Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 болон 72.2-т зааснаар Татварын алба нь буцаан олгох татварыг холбогдох актаар баталгаажуулан ажлын 30 хоногийн дотор буцаах олгох хуулийн хугацаа нэгэнт өнгөрсөнтэй холбоотойгоор гомдол гаргасан. давж заалдах шатны шүүхээс Гэтэл Давж заалдах шатны шүүх хянан баталгаажуулалтыг татварын байгууллагад хийхийг дахин даалгаад байгаа нь ойлгомжгүй байна.
- 33. Нэхэмжлэгчийн зүгээс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13.4 дэх заалтаар татварын хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас төлөх татварын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн бол хамаарахгүй байхаар заасныг хууль тогтоомжийн бусад зохицуулалт, эрхийнхээ хүрээнд Том татвар төлөгчийн газарт гаргасан хүсэлтдээ цаашид тогворжуулах гэрчилгээ олгох үед хүчин төгөлдөр мөрдөж байсан Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолын дагуу АМНАТ төлөх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсан үйл баримт нь агуулгын хувьд Засгийн газрын 2021 оны 174 болон 2019 оны 465 дугаар тогтоолууд тогтворжуулах гэрчилгээ бүхий нэхэмжлэгчийн АМНАТ төлөх харилцаанд нь хамаарахгүй болохыг шийдвэрлүүлэхээр хандаж байсныг илэрхийлнэ. Давж заалдах шатны шүүхээс энэхүү үйл баримтыг үнэлэлгүйгээр, урьдчилсан шатанд огт асуудал тавьж байгаагүй мэтээр дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Иймд дээрд дурдсан үндэслэлүүдээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 334 дугаартай магадлал нь “хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” шаардлагыг хангаагүй, хууль хэрэглээний илэрхий алдаатай байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.3-т заасны дагуу магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 243 дугаартай шийдвэрийг хэвээр үлдээж өгнө ҮҮ.

Хавсаргасан баримт:

- 1. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт -1 хуудас.

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ



Д.ҮҮРЦАЙХ  
Э.ГАНБАТ  
Д.ДАВААБИЛЭГ

**Жич:** Хяналтын шатны шүүх хуралд өмгөөлөгчдийн хамт биечлэн оролцож, тайлбар гаргах хүсэлтэй байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасан журмын дагуу хяналтын шатны шүүх хуралдааны товыг мэдэгдэж өгнө ҮҮ.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ЗАХИРГЛАНЫ ХЭРГИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД

Гомдол гаргах нь:

Энержи ресурс ХХК-ийн нэхэмжлэлтэй, Том татвар төлөгчийн газарт холбогдох захиргааны хэргийг хянаад, шийдвэрлэсэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 сарын 18-ны өдрийн 128/ШШ/2024/0243 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 221/МА2024/334 дугаартай магадлалыг эс зөвшөөрч ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2-т "шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна" гэсэнтэй нийцээгүй гэж үзэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсэгт зааснаар шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэх үндэслэлээр улсын дээд шүүхэд хянуулахаар гомдол гаргаж байна.

**Шүүхийн магадлалын үндэслэл хэсгийн 2.1.4-д** Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Татвар төлөгч дараах эрх эдэлнэ" гээд 12.1.7-д "татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх", 12.1.11-д "хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх" эрхтэй гэж заасан бөгөөд нэхэмжлэгч нь хуулиар олгосон энэ эрхийнхээ хүрээнд хариуцагч захиргааны байгууллагад хүсэлт гаргасан байхад Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газраас тус хүсэлттэй холбогдуулан ямар ч хяналт, шалгалт хийгээгүй атлаа "...танай компанийн тогтворжуулах гэрчилгээгээр тогтворжуулсан хувь хэмжээнд хуулиар өөрчлөлт ороогүй байх тул илүү төлсөн гэх 221.4 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг баталгаажуулах боломжгүй" гэж шууд татгалзсан нь дээрх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба хянан шалгана", 41.4-д "Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана" гэснийг,

Мөн Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Хувь хүн, хуулийн этгээдийн Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ", 15.1.2-т "харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянан шалгаж, баталгаажуулахаар албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 15.8-д "Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.2, 15.4, 15.7, 15.18-д зааснаар ирүүлсэн хүсэлт, саналыг хүлээн авснаас хойш ажлын долоон өдөрт багтаан хянаж буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж, энэ тухай албан татвар төлөгчид

бичгээр буюу цахим хэлбэрээр мэдэгдэж, буцааж олгох албан татварын хэмжээ, өрийн дүн зэргийг хянан баталгаажуулж, албан татвар буцаан олгох саналыг ажлын хоёр өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэснийг тус тус зөрчжээ.гэжээ.

**Энэ нь дараах үндэслэлээр хуульд нийцээгүй шийдвэр болсон гэж үзэж байна.**

Хөрөнгө оруулалтын тухай хууль /2013 оны/ -ийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно." гэж заасны дагуу Монгол улсын эрх бүхий байгууллагаас 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 24 жилийн хугацаанд 4 төрлийн татварын хувь хэмжээг тогтворжуулахаар 001 тоот "Тогтворжуулах гэрчилгээ" авсан.

Тогтворжуулах гэрчилгээний хавсралт хэсэгт "2015 оны 08 дугаар сарын 13-ны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд заасан хувь, хэмжээг тогтворжуулав" гэж нэмэлт хэлбэрээр заасан нь экспортлогдсон нүүрсэнд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн үндсэн хувь хэмжээг 5,0%, нэмэлт хувь хэмжээг боловсруулаагүй нүүрсний хувьд 1.0%-5.0%, баяжуулсан нүүрсний хувьд 1.0%-3.0% хувиар тогтворжуулан баталгаажуулсан болох нь тодорхой байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47.15-д Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь хэмжээгээр ногдуулна гэж заасан нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд нэхэмжлэгч талд 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдөр олгосон 001 тоот гэрчилгээнд дурьдсанаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зөвхөн хувь хэмжээг нь хуулийн хүрээнд тогтворжуулсан болох нь тодорхой байна.

Тогтворжуулах гэрчилгээгээр тогтворжуулсан ашигт малтмалын төлбөрийн хувь хэмжээ нь ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс өөр ялгаатай ойлголт бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд дараах байдлаар хуульчилсан байгаа нь борлуулалтын үнэлгээг төлбөрийн хувь хэмжээтэй нэг ойлголт гэж үзсэн шүүхийн үндэслэл няцаагдана.

#### **Ашигт малтмалын борлуулалтын үнэлгээ**

47.2.Энэ хуулийн 47.16-д заасан борлуулалтын үнэлгээг дараахь журмаар тооцно:

47.2.1.экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунжийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

## **Ашигт малтмалын төлбөрийн хувь хэмжээ:**

47.3. Ашигт малтмалын нооц ашигласны толборийг дараах хэмжээгээр ногдуулна:

47.3.1. олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь;

47.3.3. энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь.

47.5. Энэ хуулийн 47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:

Энержи ресурс ХХК нь экспортод гаргаж буй нүүрсэндээ АМТХ-ийн 47.2.1. экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан борлуулалтын үнэлгээг тооцно гэж заасны дагуу борлуулалтын үнэлгээг олон улсын зах зээлийн үнээр тооцох болсноос төлөх татвар нэмэгдсэн.

Энэ нь Тогтворжуулах гэрчилгээний хавсралт хэсэгт "2015 оны 08 дугаар сарын 13-ны байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд заасан хувь, хэмжээг тогтворжуулав" гэж заасан эрхэд хамааралгүй, тодруулбал тогтворжуулах гэрчилгээгээр баталгаажуулсан хувь хэмжээнээс хамааралгүйгээр Ашигт малтмалын тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасан борлуулалтын үнэлгээг зах зээлийн үнээр тооцсноос үүссэн зөрүү юм. Өөрөөр хэлбэл татварын суурь буюу АМНАТ ногдуулах ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс хамааралтай төлөх татвар нэмэгдсэн. Борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцохыг АМТХ-ийн 47.2 дахь заалтаар нарийвчлан зохицуулсан байдаг бөгөөд борлуулалтын үнэлгээг тогтворжуулах гэх ойлголт байхгүй бөгөөд энэхүү үнэлгээ нь олон улсын зах зээлийн үнэ, валютын хнашийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөж байдаг тогтворжуулах боломжгүй харилцаа байдаг.

Засгийн газрын тогтоолоор ашигт малтмалын төлбөрийн хувь хэмжээг тогтоодоггүй, харин Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1 дэх хэсгийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцох аргачлалыг Засгийн газрын 2014 оны 220-р дугаар тогтоолоор журамласан байдаг. **Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолын 2-р хавсралтаар "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал"-ыг баталсан бөгөөд энэ аргачлалаар АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцохыг зохицуулснаас бусдаар АМНАТ-ийн хувь хэмжээг зохицуулаагүй, төлбөр төлөгчийн төлөх төлбөрийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн шинээр татварын харилцаа үүсгээгүй.**

Засгийн газрын 2014 оны 220 дугаар тогтоолын 2-р хавсралтаар "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал" –аар борлуулалтын үнэлгээг бусад аж ахуйн нэгжтэй харьцуулалт хийн 10 хувь дотор зөрүүтэй байвал хэлцлийн үнэ буюу татвар төлөгчийн гэрээнд заасан үнээр борлуулалтын үнэлгээг тооцох эсэхийг татварын алба

тогтоож байсан бөгөөд энэхүү аргачлал нь 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн Засгийн 342 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.

Нэгэнт Засгийн газрын борлуулалтын үнэлгээ тооцох **аргачлал** хүчингүй болсон тохиолдолд хүчингүй болсон аргачлалыг үндэслэн зөвхөн нэг хуулийн этгээд нүүрсний борлуулалтын үнэлгээгээр гэрээний үнээр тооцуулна гээд байх боломжгүй. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд АМНАТ-ын борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцох асуудал бусад ААН-ийн адил хэрэгжих ёстой.

Татварын алба нь уг компанийн хүсэлтийн дагуу төсөвт төлөх АМНАТ яагаад нэмэгдсэн асуудлыг судлан, шалгаж үзээд тогтворжуулах гэрчилгээгээр олгогдсон татварын хувь хэмжээнээс бус борлуулалтын үнэлгээнээс үүссэн болохыг тогтоосон, энэ талаараа хариуг татвар төлөгчид мэдэгдсэн.

Мөн Том татвар төлөгчийн газрын Хяналт шалгалтын байцаагчид нь Энержи ресурс ХХК-ийн 2019.01.01—2021.12.31 өдрийг дуусталх хугацааг хамруулан татварын ногдуулалт төлөлтийн байдалд иж бүрэн хяналт шалгалтыг хийж 2023.12.28-ны өдөр НА-21230000089 дугаар акт тогтоосныг татвар төлөгч хүлээн зөвшөөрөн актаар ногдуулсан төлбөрийг төсөвт төлсөн байдаг. Уг актаар татвар төлөгчийн АМНАТ тайлангаар илүү төлсөн гэх 2019-2021 оны татвар ногдуулалт төлөлтийн байдлыг шалгаад хуульд нийцсэн, илүү ч төлөөгүй дутуу ч төлөөгүй болохыг дээрх актаар баталгаажуулсныг татвар төлөгч зөвшөөрсөн байдаг.

Тиймээс татварын албыг шалгаагүй гэж үзсэн шүүхийн магадлал үгүйсгэгдэж байна. Энержи ресурс ХХК нь 2019 онд нийт **75,864,295,496,38 төгрөгийн АМНАТ төлөхөөр тайлагнасныг татварын улсын байцаагчид шалгаад зөрүү үүсээгүй зөв гэж үзснийг татвар төлөгч зөвшөөрсөн /НА-21230000089 актын хавсралт маягт ХШ-07/06/, 2020 онд нийт **55,604,512,301,19 төгрөгийн АМНАТ төлөхөөр тайлагнасныг татварын улсын байцаагчид шалгаад зөрүү үүсээгүй зөв гэж үзснийг татвар төлөгч зөвшөөрсөн /НА-21230000089 актын хавсралт маягт ХШ-07/06/, 2021 онд нийт **57,526,015,514.80 төгрөгийн АМНАТ төлөхөөр тайлагнасныг татварын улсын байцаагчид шалгаад зөрүү үүсээгүй зөв гэж үзснийг татвар төлөгч зөвшөөрсөн /НА-21230000089 актын хавсралт маягт ХШ-07/06/** эдгээр баримтаар татварын алба шалгаагүй, судлаагүй, шалгах ёстой гэж үзсэн шүүхийн үндэслэл няцаагдана.****

НӨАТ-ын тухай хуулийн 15 дахь заалтыг татварын алба зөрчсөн гэж шүүх үзсэн.

Энержи ресурс ХХК нь АМНАТ-ын ногдуулалт төлөлтэй холбоотой асуудлаар маргаан үүсгэсэн бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татварын харилцааг зохицуулсан журам энэ харилцаанд үйлчлэхгүй. Шүүхийн энэхүү дүгнэлт нь Татварын ерөнхий хуулийн 3.2.Энэ хуулиар зохицуулаагүй, эсхүл энэ хуульд зааснаас өөрөөр татварын бусад хуульд заасан бол тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийн зүйл, хэсэг, заалт давуу үйлчилнэ, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 1.1.Энэ хуулийн зорилт нь нэмэгдсэн өртгийн албан татвар /цаашид "албан татвар" гэх/-ыг ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, буцаан олгох, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасантай нийцээгүй шийдвэр болсон байна гэж үзнэ.

Мөн нэхэмжлэлийн шаардлагад дурдагдаад байгаа Засгийн газрын 2014 оны 220, 2019 оны 342, 2021 оны 174 дүгээр тогтоолуудаар ашигт малтмалын төлбөрийн хувь

хэмжээг зохицуулаагүй бөгөөд борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцохыг аргачлал болгосон байдаг.

Тодруулж хэлбэл Засгийн газрын 2014 оны 220, 2019 оны 342 дугаар тогтоолуудаар ашигт малтмалын төлбөрийн хувь хэмжээг тогтоогоогүй, борлуулалтын үнэлгээг ч тогтоогоогүй зөвхөн хуулиар тогтоосон буюу АМТХ-ийн 47.2 дахь хэсэгт заасан борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцохыг тодорхойсон аргачлал юм. Ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг АМТХ-ийн 47.2.1, 47.2.2, 47.2.3 дахь хэсгээр хуульчилж өгсөн бөгөөд АМТХ-ийн 47.2.1 дэх хэсэгт заасан экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болох зах зээлийн үнийн эх сурвалжийг Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд уг тогтоолын 2-р хавсралтын 7 дахь хэсэгт "Нүүрс" бүтээгдэхүүний экспортын борлуулалтын үнэлгээг БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн үнэ ("<http://en.sxcoal.com>") гэж тогтоосон.

Дээрхээс үзвэл Энержи ресурс ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй, дээрх тогтоолуудаар төлбөрийн хувь хэмжээг зохицуулаагүй болох нь тодорхой байна.

Иймд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 сарын 18-ны өдрийн 128/ШШ/2024/0243 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 221/МА2024/334 дугаартай магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэгч Энержи ресурс ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж өгнө үү.

ГОМДОЛ ГАРГАСАН:

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ



Ц.ТОГОСМАА